

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/17/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг Төрийн Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Отгонбаяр
Утас: 89306788 Цахим хаяг: otgonbayarde@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
4.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.27 № 01/297
танай _____-ны № _____-т

ТҮНЭЛ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ Д.ЦОГБАЯР
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Түнэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түнэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагуудын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэнтэй холбоотой нийт хөрөнгө 6,122.1 сая төгрөг буюу 60.7 хувиар буурсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын явцад Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг 22.1 сая төгрөгөөр бууруулж тусгасныг залруулж, зээлийн авлагын эцсийн үлдэгдлийг 54.2 сая төгрөгөөр тайлагнасан.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Түнэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч Хөвсгөл аймгийн Засаг даргатай тайлант онд 7 чиглэлээр 134 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг 98 хувиар дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,120,484.2	520,704.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	446,113.9	291,162.6
33	АВЛАГА	130,307.5	80,825.9
35	БАРАА МАТЕРИАЛ	544,062.9	148,716.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,967,654.4	3,355,404.8
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	74,038.0	95,911.1
37300	Урт хугацаат зээл	74,038.0	95,911.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,893,616.3	3,259,493.8
39200	Биет хөрөнгө	8,787,627.6	3,224,442.5
39300	Биет бус хөрөнгө	105,988.7	35,051.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,088,138.6	3,876,109.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	26,393.2	25,585.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	26,393.2	25,585.8
41300	Өглөг	25,326.3	25,506.2
41400	Урьдчилж орсон орлого	1,066.8	79.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,061,745.4	3,850,523.5
51	Засгийн газрын хувь оролцоо	10,061,745.4	3,850,523.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	3,893,390.6	2,770,588.9
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	3,893,390.6	2,770,588.9
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	173,862.6	178,862.6
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	203,969.6	279,059.6
51200	Хуримтлагдсан үр дүн	4,812,639.8	256,574.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	967,882.8	365,438.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,088,138.6	3,876,109.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,455,263.5	1,009,548.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	375,981.7	426,507.5
110	Орлогын албан татвар	66,738.2	218,414.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	66,738.2	233,441.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-15,027.4
113	Хөрөнгийн албан татвар	32,590.6	73,746.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	276,652.9	134,347.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,187,897.3	-142,620.3
120	Нийтлэг татварын бус орлого	2,187,897.3	-142,620.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,891,384.4	725,661.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,824,386.9	1,074,382.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,824,386.9	1,074,382.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,743,705.0	973,839.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,777,314.6	393,511.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	234,643.7	45,686.0

Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,005.1	23,981.7
2104	Хангамж, бараа материалын зардал	91,311.0	197,353.5
2105	Норматив зардал	120,846.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,466.2	36,362.3
2107	Томиллолт, зочны зардал	6,170.5	4,474.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,641.4	105,870.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	356,306.6	166,599.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,681.9	100,543.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,630,876.5	-64,833.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	199,786.2	6,159,665.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,431,090.3	-6,224,499.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

		(мянган төгрөгөөр)	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,381,867.0	1,237,422.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	375,981.7	426,507.5
110	Орлогын албан татвар	66,738.2	218,414.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	66,738.2	233,441.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-15,027.4
113	Хөрөнгийн албан татвар	32,590.6	73,746.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	276,652.9	134,347.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	22,232.1	12,236.3
1181	Газрын төлбөр	4,757.5	26,681.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	249,663.3	95,429.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	152,682.3	77,713.2
120	Нийтлэг татварын бус орлого	152,682.3	77,713.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,853,202.9	733,201.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,886,133.2	1,282,329.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,886,133.2	1,282,329.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,823,351.2	1,014,355.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,867,114.4	510,126.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	261,230.9	75,398.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,907.9	50,978.9
2104	Хангамж, бараа материалын зардал	232,084.5	178,838.4
2105	Норматив зардал	151,694.4	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,514.8	41,682.1
2107	Томиллолт, зочны зардал	6,170.5	4,474.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,310.9	110,831.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,322.9	42,026.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,782.0	267,974.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	495,733.8	-44,907.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	199,413.1	50,044.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	199,413.1	50,044.2
2200	Дотоод эх үүсвэрээр	199,413.1	50,044.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-199,413.1	-50,044.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-73,754.1	-60,000.0

Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	73,754.1	60,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	222,566.6	-154,951.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	223,547.3	446,113.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	446,113.9	291,162.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,442,143.50	0.00	7,442,143.50
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-184,908.50	0.00	-184,908.50
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,257,235.00	0.00	7,257,235.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-14,412.20	0.00	-14,412.20
7	Өмчид гарсан өөрчлөлт	387,832.30	0.00	387,832.30
9	Тайлант үеийн үр дүн	2,431,090.30	0.00	2,431,090.30
10	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,061,745.40	0.00	10,061,745.40
11	2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	10,061,745.40	0.00	10,061,745.40
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-62,657.40	0.00	-62,657.40
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,999,088.00	0.00	9,999,088.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	75,934.50	0.00	75,934.50
19	Тайлант үеийн үр дүн	-6,224,499.00	0.00	-6,224,499.00
20	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,850,523.50	0.00	3,850,523.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,406,650.00	1,241,780.58	-164,869.42	-13.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,285,908.40	1,181,780.58	-104,127.82	-8.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,034,984.10	1,006,968.85	-28,015.25	-2.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	408,311.60	397,057.88	-11,253.72	-2.8
210101	Үндсэн цалин	320,873.00	311,039.96	-9,833.04	-3.2
210102	Нэмэгдэл	63,690.90	64,831.80	1,140.90	1.8
210104	Урамшуулал	23,747.70	21,186.12	-2,561.58	-12.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,863.30	43,055.75	-3,807.55	-8.8

Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	31,971.20	29,932.53	-2,038.67	-6.8
210202	Тэтгэмжийн даатгал	3,723.00	3,283.98	-439.02	-13.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,978.40	2,621.63	-356.77	-13.6
210204	Ажилгүйдлийн даатгал	744.60	649.46	-95.14	-14.6
210205	Эрүүл мэндийн даатгал	7,446.10	6,568.16	-877.94	-13.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	363,917.90	357,797.21	-6,120.69	-1.7
210301	Гэрэл, цахилгаан	20,500.00	20,995.51	495.51	2.4
210302	Түлш, халаалт	338,237.60	332,535.23	-5,702.37	-1.7
210303	Цэвэр, бохир ус	5,180.30	4,266.47	-913.83	-21.4
2104	Хангамж, бараа материалын зардал	40,154.90	40,057.55	-97.36	-0.2
210401	Бичиг хэрэг	12,240.80	12,180.92	-59.88	-0.5
210402	Тээвэр, шатахуун	19,392.10	19,388.33	-3.77	0.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,300.00	3,300.00	0.00	0.0
210404	Ном, хэвлэл	872.00	866.48	-5.52	-0.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250.00	221.85	-28.15	-12.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,100.00	4,099.97	-0.03	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,701.70	73,586.72	-114.98	-0.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000.00	8,000.00	0.00	0.0
210602	Тавилга	30,424.80	30,388.80	-36.00	-0.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500.00	500.00	0.00	0.0
210604	Урсгал засвар	34,776.90	34,697.92	-78.98	-0.2
2107	Томилолт, зочны зардал	4,500.00	4,474.00	-26.00	-0.6
210702	Дотоод албан томилолт	4,500.00	4,474.00	-26.00	-0.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,334.70	54,758.14	-6,576.56	-12.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,684.70	52,844.35	-5,840.35	-11.1
210803	Даатгалын үйлчилгээ	500.00	500.00	0.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300.00	289.27	-10.73	-3.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150.00	33.00	-117.00	22.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000.00	999.50	-0.50	-0.1
210807	Газрын төлбөр	700.00	92.00	-608.00	13.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,200.00	36,181.60	-18.40	-0.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,200.00	31,200.00	0.00	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000.00	4,981.60	-18.40	-0.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250,924.30	174,811.73	-76,112.57	-43.5
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	222,083.20	145,980.65	-76,102.55	-52.1
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	222,083.20	145,980.65	-76,102.55	-52.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,841.10	28,831.08	-10.02	0.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,329.60	17,329.60	0.00	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,511.50	11,501.48	-10.02	-0.1

Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,741.60	60,000.00	-60,741.60	
230001	Эргэж төлөгдөх зээл	120,741.60	60,000.00	-60,741.60	-101.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,406,650.00	1,271,894.79	134,755.21	-10.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	128,837.00	183,115.14	54,278.14	29.6
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	128,837.00	183,115.14	54,278.14	29.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	886,717.20	1,040,391.10	153,673.90	14.8
320001	Орон нутгийн төсвөөс	886,717.20	1,040,391.10	153,673.90	14.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	391,095.80	48,388.55	342,707.25	-708.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	75,000.00	43,837.62	-31,162.38	-71.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,550.93	4,550.93	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		83,286.52	83,286.52	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		104,657.83	104,656.83	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	116.00	48.00		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00		
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	57.00	23.00		
620001	Удирдах ажилтан	10.00	10.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00		
620003	Үйлчлэх ажилтан	36.00	2.00		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	57.00	23.00		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	39.00	5.00		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9.00	9.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Код	Үзүүлэлт	(мянган төгрөгөөр) ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	55,139.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	55,139.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,194.8
2104	Хангамж, бараа материалын зардал	5,735.0
210401	Бичиг хэрэг	629.0
210402	Тээвэр, шатахуун	5,076.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,459.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,459.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,944.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,680.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,680.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,264.5
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	17,568.8
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,695.7

I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	37,570.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,570.4
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	18,795.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,171.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,604.0
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-17,568.8
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,568.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Түнэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь "Төрийн үйлчилгээг шуурхай иргэн бүрд тэгш хүртээмжтэй, нээлттэй ил тод, өрх гэр бүлийн амьжиргааг дээшлүүлэх жижиг дунд үйлдвэрлэл мал аж ахуйг хөгжүүлж ажлын байр нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл ядуурлыг бууруулах, иргэдээ эрүүл аюулгүй орчинтой шинэ суманд сэтгэл хангалуун амьдруулах" зорилгыг дэвшүүлэн "Бүтээлчээр сэтгэж – Хамтдаа хөгжье" уриа зарлан ажилласан байна.

Тус сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 76.8 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй. Тус төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нийт 2 байгууллага, орон нутгийн 2 сан, Ерөнхий орлогын данс, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн хаалтын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулжээ. Засгийн газрын 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул Түнэл сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийг улсын төсөвт шилжүүлсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас нэгдсэн байдлаар боловсруулан мөрдүүлж байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд томоохон өөрчлөлт ороогүй байна. Тайлант онд шинээр Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлсэн.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгжийг Засаг даргын 2021 оны А/10 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх дотоод хяналтын нэгжийн хяналт шалгалт явуулах журмыг сумын Засаг даргын 2017 оны А/12 захирамжаар баталсан байна. Дотоод хяналтын нэгж нь тайлант онд төлөвлөгөөний дагуу 2 удаа төсөвт 6 байгууллагын шилэн данс, хөрөнгийн тооллогын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж, засаг даргын албан тоотоор зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэн, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан хэдий ч үр дүнг тооцож илэрсэн зөрчлийг арилгасан эсэхэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь 2022 онд тус сумын төсөвт байгууллагын 2020-2021 оны санхүүд баримтын шалгалт хийсэн байна.

Дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын нэгжийн гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын нэгжээс шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-д нийцүүлэн нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ. Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түнэл сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,212.0 сая төгрөгөөр буурсан нь байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт Б	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	446.1	291.2	-154.9
Авлага	130.3	80.8	-49.5
Бараа материал	544.1	148.7	-395.4
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,120.5	520.7	-599.8
Урт хугацаат хөрөнгө оруулалт	74.0	95.9	21.9
Үндсэн хөрөнгө	8,893.6	3,259.5	-5,634.2
Нийт хөрөнгө	10,088.1	3,876.1	-6,212.0
Өр төлбөр	26.4	25.5	-0.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,061.7	3,850.5	-6,211.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,088.1	3,876.1	-6,212.0

Эх сурвалж: Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данс данс өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө өмнөх оноос 154.9 сая төгрөгөөр буурсан нь Хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл урд оноос 13.6 сая төгрөгөөр, сумын орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл өмнөх оноос 161.5 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

- Авлага 49.5 сая төгрөгөөр буурч 80.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба үүнээс Хоршоо хөгжүүлэх сангийн 2 иргэн, 1 аж ахуйн нэгжтэй холбоотой хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэл 14.0 сая төгрөг байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 395.4 сая төгрөгөөр буурахад төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан байгууллагын бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн нь нөлөөлсөн байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль 157.9 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 93.0 сая төгрөг, соёлын төв 4.1 сая төгрөг, эрүүл мэндийн төв 172.2 сая төгрөгийн бараа материалыг тус тус шилжүүлсэн байна.
- Урт хугацаат зээл 21.9 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангаас 60 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Энэ нь Хоршоо хөгжүүлэх сангийн 1 жилээс дээш хугацааны дараа төлөгдөх зээлийн үлдэгдэл юм.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,634.2 сая төгрөгөөр буурахад "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Үүнд: Соёлын төвийн 107.8 сая төгрөг, Ерөнхий боловсрол сургуулийн 2,560.4 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн 1,359.6 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгийн 1,667.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотойгоор буурсан байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 1,009.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 4,447.3 сая төгрөгөөр буюу 81.5 хувиар буурсан байна.

Хүснэгт №9 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	376.0	426.5	50.6	13.5
Татварын бус орлого	2,187.9	-142.3	-2330.2	-92.5
Тусламж санхүүжилтийн орлого	2,891.4	725.7	-2,165.7	-18.6
Нийт дүн	5,455.3	1,009.9	-4,447.3	81.5

Эх сурвалж: Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын тайлан улсын төсөвт шилжсэнтэй холбоотойгоор үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, санхүүжилтийн орлого зэрэг нь нөлөөлсөн байна. Татварын орлого өссөн нь орон нутгийн орлого нийт дүнгээр давж биелсэнтэй холбоотой байна. Түнэл илч ХХК-ийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийг үйл ажиллагааны зардалд оруулж нэгтгээгүй, төсвийн байгууллагад өгсөн халаалтын орлогыг устгахад татварын бус орлого сөрөг утгатай болсон байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын хоорондын тооцоогоор 1,448.4 сая төгрөгийн орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 7,234.1 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт №10: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	2,824.4	1,074.4	-1,750.0	38.0
Үйл ажиллагааны бус зардал	199.8	6,159.7	5,959.9	70.2
Нийт дүн	3,024.2	7,234.1	4,209.9	139.2

Эх сурвалж: Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нийт зардлын дүн өмнөх оноос 1,750.0 сая төгрөгөөр буурсан нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан байгууллага 4 улсын төсөвт шилжиж хаалтын тайлан хийсэнтэй холбоотойгоор үйл ажиллагааны бус зардлын дүн 6,159.7 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1448.5 сая төгрөгийн зарлагын давхардсан 13 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1448.4 сая төгрөгийн зарлагын давхардсан 13 гүйлгээ устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны орлогын төсвийн төслийг 1,405.1 сая төгрөгөөр, зардлын төсвийн төслийг 1,651.0 сая төгрөгөөр нэгтгэж аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажилласан байна.

Түнэл сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 1,467.5 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Нийт зардлын 222.1 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 347.4 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 75 сая төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, давсан орлого дансны үлдэгдлээс 246.9 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр 891.4 сая төгрөг төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Түнэл сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 12 дугаар дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэгийг 192.9 сая төгрөгийн хасах тодотгол хийж төсвийг 772.5 сая төгрөгөөр баталсан байна. Тогтоолын 2 дугаар хавсралтаар орон нутгийн ерөнхий орлогын дансны 2021 оны үлдэгдэл 26.2 сая төгрөг, 2021 оны давсан орлого 10.5 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 1.7 сая төгрөгийг тус тус нэмж баталсан. Хасах тодотгол хийсэн нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагад ажиллагсдын цалинг улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Гүйцэтгэлээр мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 83.3 сая төгрөг дээр орон нутгийн төсвийн санхүүжилт 1,040.4 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 43.8 сая төгрөг, хүүгийн эргэн төлөлт 4.6 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас 183.1 сая төгрөгийн санхүүжилтийн орлого орж, 1,167.3 сая төгрөг зарцуулж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 104.6 сая төгрөг байна.

Төсвийн орлого бүрдүүлэлтийг харуулбал:

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Түнэл сумын ИТХ-ын 2022 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 04 дүгээр тогтоолд зааснаар Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 470.5 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна.

Түнэл сумын ИТХ-ын 2022 оны орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай 2022 оны 7 дугаар сарын 4-ны өдрийн 1 дүгээр тогтоолд зааснаар Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 346.2 сая төгрөгийн орлогыг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 387.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 112 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №11. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
ОРОН НУТГИЙН ОРЛОГО	346.2	387.8	41.6	112.0
Татварын орлого	339.5	387.8	48.3	114.2
Орлогын албан татвар	192.9	179.8	-13.1	93.2
Хувь хүний орлогын албан татвар	192.9	218.1	25.2	113.1
Цалин хөлс, шагнал урамшил	155.1	161.7	6.6	104.3

Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үйл ажиллагааны орлого	15.7	20.6	4.9	131.2
Хөрөнгийн орлого	22	20.9	-1.1	95.0
Хөрөнгө борлуулсны орлого	14.8	27.2	12.4	183.8
Шууд бус орлого	0.4	2.8	2.4	700.0
ХХОАТ буцаан олголт	-15.1	-15.1	0	100.0
Хөрөнгийн албан татвар	42	73.8	31.8	175.7
Бууны албан татвар	2.4	3.1	0.7	129.2
ҮХЭХАТатвар	2.7	2.5	-0.2	92.6
Малын тоо толгойн албан татвар	36.9	68.2	31.3	184.8
Бусад татвар, төлбөр, хураамж	103.5	116.51	13.01	112.6
Бусад нийтлэг төлбөр, хураамж	13.5	12.1	-1.4	89.6
Улсын тэмдэгтийн хураамж	7	4.4	-2.6	62.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1	1.1	0.1	110.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5.5	6.6	1.1	120.0
Газрын төлбөр	8.7	26.6	17.9	305.7
Газрын төлбөр	8.7	7.7	-1	88.5
Дуудлага худалдаа	0	18.9	18.9	-
Байгалийн нөөц ашигласны төлбөр	82.2	95.31	13.11	115.9
Ойн нөөц ашигласны төлбөр	75.6	88.9	13.3	117.6
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.1	0.01	-0.09	10.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	2	1.3	-0.7	65.0
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	4.5	5.1	0.6	113.3
Татварын бус орлого	7.8	9.1	1.3	116.7
Хувьцааны ногдол ашиг	2	0	-2	-
Торгуулийн орлого	5.8	9.1	3.3	156.9

Эх сурвалж: Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Түнэл сумын орон нутгийн орлого 41.6 сая төгрөгөөр давж биелэхэд хувь хүний орлогын татвар 25.2 сая төгрөг, хөрөнгийн татвараас малын тоо толгойн албан татвар 31.3 сая төгрөг, байгалийн нөөц ашигласны төлбөр хураамжаас ойн нөөц ашигласны төлбөр 13.3 сая төгрөгөөр давж биелсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн орлогоос 5 нэр төрлийн 5.6 сая төгрөгийг орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Орон нутгийн төлөвлөгөө биелээгүй орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Хөрөнгийн орлого 1.1 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 0.2 сая төгрөг, Улсын тэмдэгтийн хураамж 2.6 сая төгрөг, газрын төлбөр 1.0 сая төгрөг, ус рашааны нөөц ашигласны төлбөр 0.7 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 21.0 сая төгрөгөөр төлөвлөж 36.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 175.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №12: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	ААНОАТ	3.0	0		
2	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	12.0	16.5	4.5	137.9
3	Зам ашигласны төлбөр	4.5	5.1	0.6	114
	Нийт дүн	19.5	21.6	5.1	110.7

Эх сурвалж: Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар 4.5 сая төгрөгийг давж биелүүлсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 16.7 сая төгрөгөөр төлөвлөж 22.9 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 6.2 сая төгрөгөөр буюу 37.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №13: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	3.0	4.6	1.6	152.9
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	13.0	15.6	2.6	120.3
3	Агаарын бохирдлын төлбөр	0.7	2.7	2.0	367.2
	Нийт дүн	16.7	22.9	6.2	137.2

Эх сурвалж: Түнэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 1406.6 сая төгрөгөөр төлөвлөж, 1241.7 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 88.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 75.0 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөж гүйцэтгэлээр 48.3 сая төгрөгийн зээл, хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлт төлөгдсөн байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 1,406.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,109.5 сая төгрөгийг урсгал зардалд, 222.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 75 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Гүйцэтгэлээр 1,060.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 347.4 сая төгрөгийг орон нутгийн орлогоос, орон нутгийг хөгжүүлэх сангаас 183.1 сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн орлогоос 48.3 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1241.7 сая төгрөг буюу 88.2 хувьтай байгаа нь Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 43 тогтоолын дагуу нийт 164.8 сая төгрөг хэмнэсэн ба Сангийн яамнаас санхүүжүүлээтэй холбоотой. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 11.2 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 3.8 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6.2 сая төгрөг
- Норматив зардал 11.6 сая төгрөг
- Эд хогшил, урсгал засварын зардал 0.1 сая төгрөг
- Томилолтын зардал 0.1 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 6.5 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 0.1 сая төгрөг
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал 60.4 сая төгрөг
- Хөрөнгийн зардал 76.1 сая төгрөг

Сум хөгжүүлэх сангийн зээл 120.7 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөж 60 сая төгрөгөөр зээл олголт хийсэн байна.

Орон нутгийн төсөвт 27.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн дүн нь Түнэл сумын ЗДТГ-ын 14.4 сая төгрөг, ЕБС-ийн 5.5 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгийн 2.2 сая төгрөг, ИТХ-ын 3.1 сая төгрөг, Соёлын төвийн 2.4 сая төгрөгөөс тус тус бүрдэж байна.

Хөрөнгө оруулалтын 16 төсөл, арга хэмжээнд 222.1 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 183.1 сая төгрөгийн санхүүжилт олгож орон нутгийн хөгжлийн сангийн дансны үлдэгдэл 66.9 сая төгрөг байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 18.7 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 11.1 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 7.6 мянган төгрөг нийт 37.6 сая төгрөгийг орлогыг бүрдүүлжээ. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түнэл сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгцдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Түнэл сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дүгээр сарын 01-ний өдрийн А/39 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1074.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 21.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 17.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой горим сорилыг хэрэгжүүлсэн. Горим сорилыг хэрэгжүүлэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Түнэл сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд 3 зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	-	3	-	100
Нийт дүн	3	-	3	-	100

Өмнөх онд тогтоосон 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Түнэл сумын Хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүг журналд бүртгэхдээ сангийн үйл ажиллагааны программын мэдээлэлд үндэслэсэн эсэхэд анхаарал хандуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 41.0 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад сум хөгжүүлэх сангийн авлага бууруулсан 22.1 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 18.9 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой 1, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой 1, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах 1 нийт 3 зөвлөмж хүргүүлж байна

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлогын данс болон харьяа 2 байгууллага, орон нутгийн 2 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, бусад байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлын хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан ЗДТГ-ын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4.1 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн. Аудитаар илэрсэн зөрчилд үндэслэн 1.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2.8 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

5.1 Залруулга

Сум хөгжүүлэх сангийн тайланд 22.1 сая төгрөгөөр авлага бууруулж, өмчийн өөрчлөлтийн тайланд эзний өмчид тайлагнасныг аудитын явцад залруулсан.

5.2 Төлбөрийн акт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.3 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөнөөс 6 нэр төрлийн 8.6 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр ханган биелүүлж ажиллах.

2. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлсэн сангийн авлагын үлдэгдэл 148.6 сая төгрөг байна. Үүнээс 2 иргэний 10.3 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоо хөгжүүлэх сангийн журам"-ын 3.4.11.Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хоцорсон зээл, хүүгийн үлдэгдлийг төвлөрүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

3. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар

3.1. Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 56.1 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрсэн. Аудитын хугацаанд 5.1 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 51.0 сая төгрөгийн 7 зөвлөмжийг өгсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хоршоо хөгжүүлэх сангийн авлага бууруулсан	1	22.1	1	22.1			1	22.1				
ДҮН	1	22.1		22.1			1	22.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	тоо	Тоо	Дүн
Хоршоо хөгжүүлсэн сангийн авлагын үлдэгдэл 146.8 сая төгрөг байна. Үүнээс 2 иргэний 10.3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл байна.	1	10.3					1	10.3				
Орон нутгийн орлогын төлөвлөгөөг дутуу биелүүлсэн	1	8.6					1	8.6				
Дүн	3	18.9						18.9				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Түнэл сумын Засаг даргын Тамгын газар	3	8.9	2	3.2			1	5.7				
Түнэл сумын ИТХ	1	0.9	1	0.9								
Түнэл-Илч ХХК	7	46.3	1	1	0	0	6	45.3				
Дүн	10	56.1	4	5.1			7	51				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ӨРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Д.ОТГОНБАЯР ОГНОО: